

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

**ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ 2011
ОНЫ БИЕЛЭЛТИЙН**

ТАЙЛАН

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2011 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ**

ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2011 ОН

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2011 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУСГАЙ ЗАХИАЛГАТ БҮТЭЭГДЭХҮҮН

Дундговь аймгийн үл хөдлөх дурсгалыг бүртгэх, тоолох ажил:

Соёлын өвийн төв нь Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суврага зэргийг бүртгэн тоолох” ажлыг 2008-2015 онуудад зохион байгуулахаар баталсныг Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 12-р сарын 07-ны өдрийн 244-р тоот тогтоолоор батлагдсан “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах хадгалах хөтөлбөр”-т туссан үл хөдлөх дурсгалтай холбоотой ажлуудтай уялдуулан хийхээр төлөвлөсөн болно.

Энэ ажлын хүрээнд Соёлын өвийн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн баг 2011 оны 9 дүгээр сарын 09-нөөс 10 дугаар сарын 14-нийг хүртэлх хугацаанд Дундговь аймгийн нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлыг хийлээ. Бүртгэл судалгааны үр дүнд тус аймгийн 15 сумын нутагт орших 292 нэрийн 4306 нэгж ширхэг дурсгалыг давтан болон шинээр илрүүлэн бүртгэж тэдгээрийг 7807 ширхэг дижитал гэрэл зураг, 6 гар зураг, 232 орчим минутын дүрс бичлэгээр баримтжуулсан байна.

Мөн сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, Соёлын төвийн эрхлэгч, багийн Засаг дарга зэрэг 50 орчим хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа.

Сумын орон нутаг судлах танхим, музейг байгуулах, үзмэр цуглуулахад нь дэмжлэг үзүүлж 6 суманд олон арван түүвэр олдворыг хүлээлгэн өгч сан хөмрөг бүрдүүлэхэд нь тусалсан болно.

Судалгааны ажлын үр дүнд:

-Эрдэнэдалай сумын нутагт буй Сангийн далай хийдийн Цогчин дуганы дээврээс ус гоожих, салхи шороо орж байна, мөн сумын нутагт орших Үнстийн хийдийн цогчин дуганы хана туурга нь бүтэн байсан хэдий ч ойрын хэдэн жил хүмүүсийн ухамсар муутай үйлдлийн золиос болж урд талын хана бүтнээрээ, баруун зүүн хана хагас, дээврийн хэсэг бүтнээрээ нурсан.

- Хуучны сүм хийд байсан газар, нурсан барилга байшингийн үлдэгдэл дээр шинээр сүм, дуган барих явдал их байгаа ба энэ нь түүх, соёлын дурсгалын дурсгалын анхны эх төрх байдлыг хэвээр нь хадгалан авч үлдэх олон улсын зарчим алдагдаж байгаа нь Дэлгэрцогт сумын Дэлгэрийн Чойрын хийдийн туурь үлдэгдэл, Сайхан-Овоо сумын Онгийн хийдийн туурь, Цагаандэлгэр сумын Цагаандэлгэрийн хийдийн туурь зэрэг газруудад тохиолдож байна.

- Сүм хийдийн барилга нь монголын барилга, хот байгуулалт нэгэн үеийн түүхийг гэрчилэх баримт, соёлын дурсгалт зүйл болдог тул сэргээн засварлалт, ашиглалт,

бүтээн байгуулалтын асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөлтөд оруулж, авран хамгаалах ажлыг нэн даруй хийх шаардлага үүссэн байна.

- Сүүлийн жилүүдэд Дундговь аймгийн нутагт орших булш, хиргисүүр, чулуужсан ургамлын үлдэгдэл бүхий дурсгалт газрыг ухаж төнхөх явдал ихээр гарч байгаа нь Сайнцагаан сумын Авдрантын дөрвөлжин булш, Дэлгэрцогт сумын Сономын хондны бууцны дөрвөлжин булшийг ойрын жилд ухаж сүйтгэсэн бол Цагаандэлгэр сумын Хүрэн дух, Өндөршил сумын Үйзэн ухаагийн палеонтологийн дурсгалт газрыг гадаад дотоодын жиптэй хүмүүс хэдэн жилийн турш ирж ухсан байдлаас харагдаж байна.

- Газрын хэвлийтэй холбоотой сум хооронд татаж буй шилэн кабелийн суваг цахилгааны хүчдэлийн шугам татах зэрэг шинэ бүтээн байгуулалтын ажлын явцад түүх, соёлын дурсгал цөөнгүй өртөж үнэ цэнээ алдаж байгаа нь булш, тахилын байгууламж, чулуун зэвсгийн дурсгалт газар зэргээр дайруулан татсан тохиолдол тус аймгийн Хулд зэрэг сумдын нутагт тааралдаж байгаа тул түүх, соёлын дурсгалыг хамгаалах чиглэлээр аймаг, сум орон нутаг болон мэргэжийн байгууллагууд тусгайлан нутаг дэвсгэр бүрт хамгаалах төлөвлөгөө, арга хэмжээ авах шаардлагатай болжээ гэж үзлээ.

Соёлын өвийн төв 2011 оны байдлаар 11 аймагт 8 удаагийн хээрийн судалгааны баг илгээж үл хөдлөх дурсгалын бүртгэлийг хийгээд байна. Цаашид 2017 он хүртэл судалгаанд хамрагдах аймгуудын хэтийн төлөвийг хавсралт 1-ээр үзүүлэв.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-1

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн RICH програм хангамжийг шинэчлэн сайжруулж, мэдээллийн санг бүрдүүлэх.

2011 оны 1-2-р улиралд “Сайбер-Андромедиа” ХХК-тай хамтран Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн “Registration of Immovable Cultural Heritage буюу RICH” програм хангамжийг шинэчлэн сайжрууллаа. Уг ажлын хүрээнд програмын зарим гэмтлийг засварлах, мэдээллийн доторх хайлтын системийг боловсронгуй болгох, дурсгалын тоо ширхэгийг нарийвчлан гаргах зэрэг өгөгдлүүдийг нэмж мэдээлэл боловсруулах боломжийг нэмэгдүүлсэн болно. Уг программ хангамжийг хэд хэдэн удаа туршиж үзсэний эцэст 2011 оны 6 дугаар сараас эхлэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг анхан шатны байдлаар бүртгэж эхэлсэн.

Энэхүү RICH програмд өнөөдрийн байдлаар бүгд **2080** нэрийн **26203** нэгж ширхэг дурсгалыг бүртгэлжүүлж тоон системд шилжүүлээд байна. /Хүснэгт №1/

УНБМСан дахь RICH програм хангамжид бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоо

№	Аймгийн нэрс	Нийт дурсгалт газар	Нийт дурсгалууд
1	Архангай аймаг	38	830
2	Баян-Өлгий аймаг	27	104

3	Баянхонгор аймаг	12	112
4	Булган аймаг	237	3058
5	Говь-Алтай аймаг	13	120
6	Говь-Сүмбэр аймаг	17	171
7	Дархан-Уул аймаг	8	39
8	Дорноговь аймаг	203	1192
9	Дорнод аймаг	163	2092
10	Дундговь аймаг	292	4306
11	Завхан аймаг	7	24
12	Орхон аймаг	23	321
13	Өвөрхангай аймаг	318	6661
14	Өмнөговь аймаг	43	134
15	Сүхбаатар аймаг	84	609
16	Сэлэнгэ аймаг	182	1771
17	Төв аймаг	22	382
18	Увс аймаг	26	337
19	Ховд аймаг	16	224
20	Хөвсгөл аймаг	21	274
21	Хэнтий аймаг	317	3431
22	Улаанбаатар хот	11	11
	Бүгд	2080	26203

Үүний **1844** нэрийн **23651** нэгж ширхэг дурсгалын бүртгэл нь “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”, 2006 оны Сангийн сайд, БСШУ-ны сайд, Мэргэжлийн Хяналтын асуудал эрхлэсэн сайд нарын хамтарсан тушаалын дагуу 2008 оноос эхлүүлэн хэрэгжүүлж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл байна. /Хүснэгт №2/

Бидний Соёлын өвийн цахим санд бүртгээд байгаа дээрх үл хөдлөх дурсгалын бүртгэл нь анхан шатны байдлаар хийгдээд байгаа бөгөөд цаашид эрдэм шинжилгээний бүтээл, тайлан болон өөрийн үйл ажиллагааны үр дүнд хуримтлуулах мэдээллээс нэмэлт бүрдүүлэлт хийхээр ажиллаж байна.

1.2 Улс, аймгийн музейгээс бүртгэн баримтжуулсан үзмэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг графикийн дагуу хүлээн авч, дижитал мэдээллийн сан бүрдүүлэх.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд улсын болон аймгийн музей, зарим нэг эрдэм шинжилгээний хүрээлэн, үндэсний номын сангийн үнэт фонд зэрэг газруудад хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгал болох музейн үзмэрийн бүртгэлийг дижитал хэлбэрээр хүлээн авч байна.

2011 оны 12-р сарын 25-ны өдрийн байдлаар улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд улсын болон аймгийн 36 музей, 2 эрдэм шинжилгээний хүрээлэн, 1 номын сан, 1 сумын орон нутаг судлах музей зэрэг нийт **34839** дэсийн **48125** ширхэг үзмэр бүртгэгдсэн байна. /Хүснэгт №3/

УНБМСан 2011 оноос эхлэн музейнүүдийн тоон системд шилжүүлсэн үзмэрийн бүртгэлийн тоог “дэс”-ийн болон “тоо ширхэг”-ийн тоон үзүүлэлтээр гаргаж эхэллээ.

2011 шинээр байгуулагдсан Хөшөө цайдам музей (Архангай аймгийн Хашаат сум), Хархорум музей (Өвөрхангай аймгийн Хархорин сум)-нүүд тус УНБМСангийн цахим сүлжээнд нэгдэж хамрагдсан.

“Энержи ресурс” ХХК-ийн захиалга, хүсэлтийн дагуу хийгдсэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэр дэх соёлын биет болон биет бус өвийг өвийг хамгаалах суурь судалгааны ажлын хүрээнд тус сумын орон нутгийг судлах танхим болон сумын зарим иргэдийн өмчлөлд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалд хамрагдаж болох зарим эдп өлгийн зүйлсийн бүртгэлийг нэмж хамруулсан байна.

Одоогийн байдлаар “RCH” бүртгэлийн програмд Улсын номын сангийн үнэтийн фонд, Говьсүмбэр, Хөвсгөл аймгууд үзмэрээ бүрэн хамруулан бүртгэжээ. Эдгээр байгууллагууд цаашдаа үзмэрийн бүртгэлээ чанаржуулах, сайжруулах, нэмэлт баяжуулалтыг хийж байх шаардлагатай.

Дараах нэр дурдсан музейнүүд үзмэр бүртгэл баримтжуулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажилдаа дүгнэлт хийж, онцгой анхаарч, ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Шинээр байгуулагдсан Хөшөө цайдам музей нэг ч бүртгэл ирүүлээгүй,
- Байгалийн түүхийн музей, Улаанбаатарын музей, Палеонтологийн хүрээлэн, Архангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь аймгийн музей 2011 онд нэг ширхэг ч үзмэрийг програмд хангамжинд нэмж бүтгээгүй,
- Ховд, Эрдэнэ зуу музей, Орхон, Төв, Хэнтий зэрэг аймгийн музей цөөн тооны үзмэр бүртгэлд хамруулсан. /Хүснэгт №3/
- 2011 онд музейнүүдээс 10788 үзмэрийн бүртгэл програм хангамжинд шилжигдэж бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхоос 588 бүртгэлээр дутуу байна. Тоон үзүүлэлтээс үзэхэд музейнүүд RCH програмд үзмэрээ бүртгэлжүүлэх нь жил бүр харилцан адилгүй байна. Цөөн тооны музейн бүртгэл хөтлөлт тогтмолжсон байна.
- Үүнээс үзэхэд музейнүүд уг програмд үзмэрээ бүртгэн оруулах бүрэн боломжтой боловч өөрсдийн идэвх санаачлагатай ажиллагаа, бүртгэн баримтжуулалтыг ажлыг тогтмолжуулахгүй хайнга хандаж байгаа нь харагдаж байна.

УНБМСанд “RCH” бүртгэлийн програмын дагуу бүртгэгдсэн музейн үзмэрийн бүртгэлийн тоон үзүүлэлт /Хүснэгт №3/

№	Байгууллагын нэрс	2010 онд бүртгэгдсэн	2011 онд нэмж бүртгэгдсэн	УНБМСанд нийт бүртгэгдсэн	
				Дэсийн тоо	Тоо ширхэг
1	Монголын Үндэсний музей	60	860	1449	1629
2	Төрийн түүхийн музей	349	130	627	636
3	Байгалийн түүхийн музей	373	0	1265	1265
4	Богд хааны ордон музей	1169	1193	3563	3594
5	Дүрслэх урлагийн музей	418	452	2071	2132
6	Чойжин ламын сүм музей	69	479	581	581
7	Монголын театрын музей	1251	1078	2901	3266
8	Монгол цэргийн музей	0	114	233	233
9	Уран зургийн галерей	330	982	1612	1635
10	Улаанбаатарын музей	16	0	407	611
11	Өвөрхангай аймаг. Хар хорум музей	-	128	128	201
12	Архангай аймаг. Хөшөө цайдам музей	-	-	-	-
13	Үндэсний номын сан	238		629	629
14	ШУА-ийн Археологийн хүрээлэн	1	135	227	2870
15	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	0	4	4	4
16	Архангай аймгийн музей	0	45	45	46
17	Баян-Өлгий аймгийн музей	182	390	868	1761
18	Баянхонгор аймгийн музей	462	368	1420	2546
19	Булган аймгийн музей	627	224	1380	2108
20	Говь-Алтай аймгийн музей	232	340	827	962
21	Говьсүмбэр аймгийн музей	-	-	295	295
22	Дархан-Уул аймгийн музей	204	19	866	866
23	Дорноговь аймгийн музей	101	404	534	904
24	Данзанравжаагийн музей	-	7	7	7
25	Дорнод аймгийн музей	480	120	1400	3222
26	Дундговь аймгийн музей	306	145	713	713
27	Завхан аймгийн музей	459	191	1450	1565
28	Орхон аймгийн музей	149	77	403	404
29	Өвөрхангай аймгийн музей	130	13	516	990
30	Өвөрхангай аймаг. Эрдэнэзуу музей	102	96	998	1058
31	Өмнөговь аймгийн музей	20	0	803	803
32	Сүхбаатар аймгийн музей	189	0	343	343
33	Сэлэнгэ аймгийн музей	700	0	851	855
34	Төв аймгийн музей	983	81	1484	1712
35	Увс аймгийн музей	755	1111	567	1992
36	Ховд аймгийн музей	83	13	213	213

37	Хөвсгөл аймгийн музей	170	1425	1795	3861
38	Хэнтий аймгийн музей	768	46	1246	1502
39	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын орон нутаг судлах танхим	-	92	92	92
40	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хувь иргэд	-	26	26	26
	Нийт	11376	10788	34839	48132

Соёлын өвийн Бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдэх /музейн 2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмөргийн улсын тооллогын дүнгээр / үзмэр бүртгэлийг, одоогийн бүртгэгдсэн байдалтай харьцуулбал дараах үзүүлэлттэй байна. УНБМСанд “RCH” бүртгэлийн програмд шилжигдэж бүртгэгдсэн үзмэрийн үзүүлэлтийг хүснэгт №4-ийн дагуу хувьчлан гаргахдаа тоо ширхэгийн үзүүлэлтийг баримтлав.

“RCH” бүртгэлийн програмд шилжигдэж бүртгэгдсэн үзмэр /Хүснэгт№4/

№	Байгууллагын нэрс	Музейн сан хөмрөгийн 2007-2008 оны улсын тооллогррх тоологдсон үзмэрийн тоон дүн		УНБМСанд нийт бүртгэгдсэн		Бүртгэгдэх ёстой үзмэрийн хэдэн хувь бүртгэгдсэн
		Дэсийн тоо	Тоо ширхэг	Дэсийн тоо	Тоо ширхэг	
1	Монголын Үндэсний музей	19874	46500	1449	1629	3.5 %
2	Төрийн түүхийн музей	-	-	627	636	
3	Байгалийн түүхийн музей	7112	13060	1265	1265	9.6 %
4	Богд хааны ордон музей	4173	8726	3563	3594	41.1 %
5	Дүрслэх урлагийн музей	7650	17840	2071	2132	11.9 %
6	Чойжин ламын сүм музей	929	6150	581	581	9.4 %
7	Монголын театрын музей	5488	7722	2901	3266	42.2 %
8	Монгол цэргийн музей	3142	8593	233	233	2.7 %
9	Уран зургийн галерей	3208	3009	1612	1635	54.9 %
10	Улаанбаатарын музей	712	3177	407	611	19.2 %
11	Өвөрхангай аймаг. Хар хорум музей	-	-	128	201	
12	Архангай аймаг. Хөшөө цайдам музей	-	-	-	-	
13	Үндэсний номын сан	495	630	629	629	99.8 %
14	ШУА-ийн Археологийн хүрээлэн	882	5942	227	2870	48.3 %
15	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн		73	4	4	5.4 %
16	Архангай аймгийн музей	1656	8133	45	46	0.5 %
17	Баян-Өлгий аймгийн музей	1412	4903	868	1761	35.9 %
18	Баянхонгор аймгийн музей	2057	7826	1420	2546	32.5 %
19	Булган аймгийн музей	2161	3922	1380	2108	53.7 %
20	Говь-Алтай аймгийн музей	1561	2514	827	962	38.2 %
21	Говьсүмбэр аймгийн музей	296	459	295	295	99.6 %
22	Дархан-Уул аймгийн музей	847	1160	866	866	74.6 %
23	Дорноговь аймгийн музей	2115	5455	534	904	16.5 %

24	Данзанравжаагийн музей	151	228	7	7	3.0 %
25	Дорнод аймгийн музей	1427	3350	1400	3222	96.1 %
26	Дундговь аймгийн музей	2766	4325	713	713	16.4 %
27	Завхан аймгийн музей	1954	3008	1450	1565	52.0 %
28	Орхон аймгийн музей	865	1510	403	404	26.7 %
29	Өвөрхангай аймгийн музей	1084	2451	516	990	40.3 %
30	Өвөрхангай аймаг. Эрдэнэзуу музей	1804	7709	998	1058	13.7 %
31	Өмнөговь аймгийн музей	919	2460	803	803	32.6 %
32	Сүхбаатар аймгийн музей	634	1741	343	343	19.7 %
33	Сэлэнгэ аймгийн музей	2039	2999	851	855	28.5 %
34	Төв аймгийн музей	3340	5348	1484	1712	32.0 %
35	Увс аймгийн музей	1248	7581	567	1992	26.2 %
36	Ховд аймгийн музей	744	2621	213	213	8.1 %
37	Хөвсгөл аймгийн музей	1712	3269	1795	3861	118.1 %
38	Хэнтий аймгийн музей	830	1715	1246	1502	87.5 %
39	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын орон нутаг судлах танхим					
40	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хувь иргэд					
	Нийт	87287	206109	34839	48132	23.35 %

Музейн үзмэрийн бүртгэлийг тоон системд шилжүүлж эхэлсэн нь соёлын өвийн бүртгэн баримтжуулж, мэдээллийн сан бүрдүүлэхэд эерэг үр дүн гарч байгаа хэдий ч зохих хэмжээнд хүрч чадахгүй байна.

Үзмэр, эд өлгийн зүйлийг музейд анх хүлээж авахдаа түүний талаарх түүх, намтар холбогдох мэдээ баримтыг дутуу дулимаг бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг бүртгэлд тусгагдаагүй байх зэрэг нь үзмэрийг бүртгэн баримтжуулалтад нөлөөлж байна. Түүнчлэн музейн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажил мэргэжлийн дагуу мэргэшүүлэн сургах, чадваржуулахад анхаарах хэрэгтэй болжээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, музейн үйл ажиллагаанд тавигдах стандарт, музейн дүрэм зэрэг холбогдох хууль, дүрмийн заалтуудыг хэрэгжүүлэн, музейнхээ бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулахад идэвх санаачлага дутагдаж байгаад музейнүүд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.3 “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог болон электрон каталог хийх

БСШУ-ны сайдын 2009 оны 303 дугаар тушаалын дагуу музейн үзмэрийн гэрэл зургийн цомог, цахим каталог хийх ажлыг 2010 оноос эхлүүлэн, 34 музей, 2 эрдэм шинжилгээний хүрээлэн, 3 сүм хийдэд хадгалагдаж байгаа 5339 түүх, соёлын хосгүй үнэт болон шилдэг үзмэрийн үзмэрийг гэрэл зургаар баримтжуулан, тодорхойлолт мэдээллийг бэлтгэсэн.

2011 оны 4 дүгээр сараас эхлэн гэрэл зургийн цомог, цахим каталоги хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүн Ж.Саруулбуян, Г.Пүрэвбат, Г.Эрэгзэн нар үзмэрийн тодорхойлолт бичлэгийг нягтлан шалгах, хянан засварлах ажлыг хийж гүйцэтгэв. БСШУЯамнаас эхний ээлжинд цахим каталогийг ашиглалтад оруулах, 2012-

2013 оны музейн сан хөмрөгийн улсын тооллогын дараа гэрэл зургийн цомгийг хэвлүүлэхээр шийдвэрлэсэн.

Цахим каталоги нь www.eheritage.mn гэсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, олон нийтэд сурталчлах зорилготой соёлын өвийн мэдээллийн нэгдсэн сайт юм. Энэхүү www.eheritage.mn домайн нэрийн дор www.movable.eheritage.mn, www.immovable.eheritage.mn, www.intangible.mn гэсэн соёлын биет болон биет бус өвийн мэдээллийн төрөлжсөн цахим хуудас хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын www.movable.eheritage.mn сайт нь музейн үзмэрийн бүртгэлийн “RCH” бүртгэлийн програмтай уялдаж ажиллах ба музейгээс уг програмд үзмэрээ бүртгэсэн тохиолдолд тухайн үзмэрийн мэдээллийг энэхүү сайт руу оруулах юм.

Тус сайтад одоогийн байдлаар түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалуудын мэдээллийг оруулаад байна. Цаашдаа улсын болон аймгийн музейн сан хөмрөг дэх шилдэг үзмэрүүдийн талаарх мэдээллийг оруулах ажил хийгдэнэ.

1.4 Өвөрхангай аймгийн 9 сумын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл тооллого, судалгаа хийх

Соёлын өвийн төв нь Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суврага зэргийг бүртгэн тоолох” ажлыг 2008-2015 онуудад зохион байгуулахаар баталсныг Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 12-р сарын 07-ны өдрийн 244-р тоот тогтоолоор батлагдсан “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах хадгалах хөтөлбөр”-т туссан үл хөдлөх дурсгалтай холбоотой ажлуудтай уялдуулан хийхээр төлөвлөсөн болно. Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн баг 2011 оны 5 дугаар сарын 23-наас 6 дугаар сарын 12-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Тарагт, Төгрөг, Баянгол, Сант, Баян-Өндөр, Есөнзүйл, Бүрд, Өлзийт, Арвайхээр гэсэн 9 сумын нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн ажлыг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд дээрх сумдын нутагт орших 180 нэрийн 4541 нэгж ширхэг дурсгалыг бүртгэн баримжуулж тэдгээрийг 3648 ширхэг гэрэл зураг, 12 ширхэг гар зураг, 113 минутын дүрс бичлэгээр баримтжуулсан байна.

Энэхүү ажлын хүрээнд дээрх сумдын холбогдох албан тушаалтныг татан оролцуулж орон нутагт бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, түүх, соёлын дурсгалыг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт үнэлгээ хийх зэрэг чиглэлээр мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн болно. Мөн зарим сумдын Орон нутаг судлах танхимын сан хөмрөгийг баяжуулахад анхаарч түүврээр олдсон чулуун зэвсгийн үлдэгдэл мэтийн олдвор эд өлгийн зүйлсийг хүлээлгэн өгсөн болно.

1.5 Өвөрхангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн үл хөдлөх дурсгалын цуврал каталог гаргах

Дээр дурдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх, тоолох ажлын үр дүнг олон нийтэд хүргэхэд үл хөдлөх дурсгалуудын гэрэл зураг, товч мэдээллийг

агуулсан каталогийг бэлтгэн, аймаг нэг бүрээр цуврал болгон хэвлүүлэн, тарааж байгаа билээ.

2011 онд “Монгол нутаг дахь үл хөдлөх дурсгал” цувралын Өвөрхангай аймаг, Сэлэнгэ аймаг болон өмнөх 2009 онд хэвлэгдсэн Сүхбаатар аймгийн каталогийн мэдээллийг нэмж сайжруулан дахин хэвлүүлж (аймаг тус бүр 1000 %-иар) тараагаад байна.

Энэ оны төлөвлөгөөнд орсон Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгуудын үл хөдлөх дурсгалуудын цуврал номыг ажлын ачаалал, хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан 2012 онд хэвлүүлэхээр хойшлуулаад байна.

Нэмэлт хийгдсэн ажлууд:

1.“Ухаа худаг” уурхайн нөлөөллийн бүс болох Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших соёлын биет болон биет бус өвийн судалгааны ажил

Соёлын өвийн төв нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Энержи Ресурс компанитай ER-11-297 тоот гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт дэвсгэрт 245 км авто тээврийн хатуу хучилттай зам дагуух “Ухаа худаг” уурхайн нөлөөллийн бүс нутаг дэвсгэрт хадгалагдан үлдсэн соёлын биет болон биет бус өвийн анхан шатны бүртгэл судалгааг хийж, хэрэглэгдэхүүндээ тулгуурлан анхан шатны БМС бүрдүүлэн, цаашид тухайн соёлын өвийг хэрхэн хамгаалах цогц хөтөлбөр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Энэхүү ажлыг 2011 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 2 сарын хугацаанд түүх, соёлын үл хөдлөх, хөдлөх дурсгал, биет бус соёлын өв гэсэн гурван чиглэлээр баг бүрдүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд багийн бүрэлдэхүүнд Соёлын төвийн мэргэжилтнүүдээс гадна ШУА-ийн харъяа Палеонтологийн төв, Хэл зохиолын хүрээлэн, Чингис хаан дээд сургууль болон Монголын урлагийн зөвлөлийн мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын судалгаанд тус сумын 23 дурсгалт газарт орших хүрэл зэвсгийн үед холбогдох булш, хадны зураг, тахилын байгууламж, зэл чулууд болон эртний хотын үлдэц, хэрэм, хэрмэн зам, хадны бичээс, хийдийн туйр зэрэг нийт 109 ширхэг дурсгалыг олж байршлыг тогтоон, бүртгэн баримтжуулсан.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын судалгаанд сумын Орон нутаг судлах музейн 92 нэрийн 101 үзмэр, эд өлгийн зүйлс, сумын уугуул 10 иргэний эдлэж хэрэглэж байгаа, урлаж бүтээсэн 37 нэрийн 47 ширхэг эд өлгийн зүйлийг өмчлөгчийн хүсэлтийн дагуу судалгаанд хамруулж анхан шатны бүртгэн бүртгэн баримтжуулах ажил хийлээ. Мөн Археологийн хүрээлэнгийн авран хамгаалах малтлагааас гарсан олдвороос 14 нэрийн 65 олдвор, Соёлын өвийн төвийн үл хөдлөх дурсгалын судалгааны багийн олж илрүүлсэн палеонтологийн 14 нэрийн 20 олдвор зэрэг нийт 164 нэрийн 240 ширхэг Цогтцэций сумын гаралтай эд өлгийн зүйлийн судалгааг гаргалаа.

Соёлын биет бус өвийн судалгааны баг уртын дуу, морин хуур, ерөөл, магтаал зэрэг биет бус өв өвлөн уламжлагч нутгийн уугуул 30 өвлөн уламжлагчийг тогтоож 780 минутын дуу дүрс бичлэг, 151 гэрэл зураг авч баримтжуулав. Судалгааны ажлын хүрээнд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 87 өвийн төрөл зүйлийг судлан тогтоов. Эдгээрээс 15% нь устаж мартагдсан өв, 21% нь яаралтай хамгаалах шаардлагатай өв нь өвлөн уламжлагчдын дунд хадгалагдаж үлджээ. Үүнд: Цогтцэций сумын нэрийн

хуудас болсон "Холч морь", "Өндрийн өвс", "Хурдан сайхан" зэрэг Говь Шанх нутгийн уртын дуунууд, "Цэцийн жонон", "Хуур магнай" зэрэг морин хуурын уламжлалт татлагууд, ерөөл, магтаал, шууд цэцлэх уламжлал, хурдан морь шинжих, уях, сойх эрдэм, айраг найрын зан үйл, ингэний сүүг боловсруулах (ингэний айраг, исгэмэл, буцалгаа, хөөрүүлэг), эмээлийн гөлөм урлал, уран хатгамал, зоос ширээ зэрэг өвүүд багтаж байна.

Соёлын өвийн төв "Ухаан худаг" төслийн нөлөөллийн бүс болон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших соёлын биет болон биет бус өвийг хамгаалах ажлын хүрээнд тус сумын нутаг дэвсгэрт буй соёлын өвийн төрөл зүйл бүрээр судалгаа хийж, бүртгэн баримтжуулсан хэрэглэгдэхүүнээр анхан шатны БМС бүрдүүлж ажиллаа.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хадгалагдан үлдсэн соёлын биет болон биет бус өвийг судлах, хамгаалах цогц хөтөлбөр боловсруулах ажлын багийнхан бага хугацаанд ихээхэн үр дүнтэй ажиллаж, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олон дурсгалыг нээж илрүүлсэн бөгөөд тус сумын нутаг дэвсгэрт соёлын өв хамгаалах, судлах, сурталчлах, хойч үед өвлүүлэх ажлыг өвийн төрөл зүйл тус бүр дээр тусгайлан анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдсан.

Түүх, соёлын хөдлөх дурсгалыг хамгаалах, бүртгэх ажлын хүрээнд нэмэлт хийгдсэн ажлууд:

2. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудын талаар:

2011 онд бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн, манай улсын музей, сүм хийд зэрэг газруудад хадгалагдаж байгаа Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Г.Занабазарын эдэлж, хэрэглэж байсан эд зүйлсийн талаарх бүртгэл, мэдээллийг нэгтгэн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу БСШУЯ-ны дэргэхэд Түүх, соёлын дурсгалт зүйлийг зэрэглэх, үнэлэх мэргэжлийн зөвлөлд санал оруулсан.

ТСДЗЗҮМэргэжлийн зөвлөлийн санал болгосны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 214 дүгээр тогтоолоор Өндөр гэгээний эдэлж, хэрэглэж байсан 16 эд зүйлсийг монголын түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд нэмж батлагдсан.

2011 онд шинээр нэмэгдэж батлагдсан хосгүй үнэт дурсгалууд

Хүснэгт5

№	Шинээр батлагдсан хосгүй үнэт дурсгалын нэрс	Хосгүй үнэт дурсгал хадгалагдаж буй байгууллага
1	Тамга, тамганы хайрцаг	Богд хааны ордон музей
2	Г.Занабазарын дээл	Богд хааны ордон музей
3	Г.Занабазарын хүүхэд ахуйн дээл	Эрдэнэ зуу музей
4	Г.Занабазарын хүүхэд ахуйн хувраг дээл	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд
5	Г.Занабазарын хүүхэд ахуйн номын хувцас	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд
6	Хос цан /Г.Занабазарын хүүхэд ахуйдаа хэрэглэж байсан/	Өвөрхангай аймаг. Шанхын Баруун хүрээ хийд
7	Г.Занабазарын гутал	Дундговь аймаг. Баруун Чойрын

		хийд
8	Г.Занабазарын дөш	Монголын Үндэсний музей
9	Бурханы хэв	Монголын Үндэсний музей
10	Суварга	Монголын Үндэсний музей
11	Г.Занабазарын хэрэглэж байсан завъяа	Монголын Үндэсний музей
12	Г.Занабазарын аяны тогоо, тогооны ширмэл уут, шүүрэн шанага	Монголын Үндэсний музей
13	Г.Занабазарын алганы дардас	Дүрслэх урлагийн музей
14	Г.Занабазарын цамц	Дүрслэх урлагийн музей
15	Г.Занабазарын зургаадай таяг	Гандантэгчилэн хийд
16	Г.Занабазарын бойвог (гутал)	Гандантэгчилэн хийд

Засгийн газрын шийдвэрээр 1995-2011 онуудад нийтдээ 609 дурсгал хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан байна.

3. Бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх сургалт зохион байгуулсан талаар:

Тус хэлтсээс музей дэх бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах, соёлын өвийг бүртгэх арга зүйн зөвлөмжөөр хангахад 2011 оны 7 дугаар сарын 18-наас 30-ны хооронд Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан зэрэг аймгийн музейнүүд дээр биечлэн очиж "Музейн соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Музейн бүртгэл-мэдээллийн санд цуглагдсан соёлын биет болон биет бус өвийн бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр хадгаламжийн нэгж үүсгэн товъёогжуулах, архивлан хадгалах, бүртгэлийн "RCH" програмд оруулсан мэдээлэлд боловсруулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, үзмэрийг хадгалж хамгаалах тухай хичээлүүдийг Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, мэргэжилтэн Б.Алтансүх, Ш.Энхтуяа, Г.Туул, сэргээн засварлагч Д.Нямдорж нар заасан.

Музейнүүдийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдлаас үзэхэд үзмэр цуглуулгын холбогдолтой цаасан болон цахим хэлбэрийн бүртгэл, баримт материалуудыг БМСанд нэгтгэх, архивлан хадгалах, тэдгээрийн холбогдох товъёогжуулалт, тоо бүртгэл хийгдэхгүй байна. /Музейн үзмэр цуглуулгын бүртгэлийн талаарх товъёогжуулалт, тоо бүртгэл хийгддэггүйгээс ерөнхий бүртгэлээ хүртэл үрэгдүүлж байсан/

Тус хэлтсээс музейн үзмэрийг "RCH" бүртгэлийн програм хангамжид шилжүүлэхээс гадна бүртгэл-мэдээллийн санд цуглагдаж байгаа цаасан болон цахим хэлбэрийн бүртгэл, баримт материалуудыг архивлан хадгалах, мэдээллийн сангийн бүрдлийг баяжуулахад музейнүүдийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна.

4. Байгалийн түүхийн музейтэй хамтран, сургалт зохион байгуулсан талаар:

Байгалийн түүхийн музейгээс санаачлан 2011 оны 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд, орон нутгийн музейн ажилтнуудад зориулан "Байгалийн үзмэрүүдийг цуглуулах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулахад хамтран ажилласан.

Сургалтанд Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл зэрэг аймгуудийн музейн эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, тайлбарлагч, бүртгэл-мэдээллийн санч нар оролцлоо. Хөдөө орон нутгийн музейнүүдэд хөхтөн амьтан, шувуу, шавьж, ургамал, геологийн дээжүүдийг хэрхэн байгалиас цуглуулж, анхан шатны боловсруулалт хийх талаар хичээл зааж дадлага хийлгэлээ. Сургалтын материалыг нэгтгэн "Музейн үзмэрүүдийг цуглуулах арга зүй" гарын авлага болгон хэвлүүлж, оролцогчдод тараасан.

5. “Монгол дахь бурханы шашны урлаг” каталогийн талаар:

Монголын музейнүүдэд хадгалагдаж байгаа бурханы шашны урлагийн бүтээлүүдийг бүртгэх, судлах, олон нийтэд сурталчлах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны санаачлагаар “Монгол дахь буддийн урлаг” төслийг 2003 оноос эхлэн Англи дахь Төвдийн сангийн ивээн тэтгэлгээр хэрэгжүүлсэн.

Соёлын өвийн төвөөс уг каталогийг бэлтгэх ажлыг зохион байгуулан ажиллаж, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Дүрслэх урлагийн музей, Эрдэнэ зуу музей, Данзанравжаагийн зэрэг музейнүүдийн сан хөмрөг дэх танка зураг, зээгт наамал, хатгамал 442 бүтээлийг багтаасан 2 цувралаас бүрдэх каталогийг 2006 онд бэлтгэж дууссан юм. Каталогид бурхан шүтээний нэрсийг монгол /крилл болон хуучин монгол бичгээр/, төвд, санскрит, англи, хятад хэлээр хадмаллан, бурхадын тайлбар тодорхойлолтыг монгол, англи хэл дээр бичсэн ба бүтээлүүдийн гэрэл зураг орсон.

Хэвлэлтийн асуудлаас шалтгаалж багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд энэ оны 10 дугаар сард номын хэвлэлт дуусч, 2011 оны 12 дугаар сард каталогийг хүлээн авсан. Уг каталоги нийт 2000 хувь хэвлэгдсэн бөгөөд үүнээс:

- 446 ширхэгийг Монгол Улсын музей, номын сан, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг холбогдох газруудад үнэ төлбөргүйгээр тараахаар бэлтгээд байна.
- 54 ширхэгийг XVI Далай ламын номын сан болон Англи дахь Төвдийн сангаас уг төсөлд оролцогчдод тараана.
- 1500 ширхэгийг нь гадаадад худалдан борлуулж, дараагийн шатны цуврал ботиудыг хийх санхүүгийн эх үүсвэр болно. Дараагийн цуврал ботудад цутгамал, хөөмөл, сийлбэр баримлын бүтээлүүд, шашны зан үйлийн эд зүйл, лам хувраг, цамын хувцас хэрэглэл, сүм хийдийн уран барилга, чимэглэл гэсэн төрлөөр, цувралыг эмхэтгэн хэвлүүлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байгаа.

Энэхүү каталоги нь бурханы шашны холбогдолтой музейн үзмэрийн нэр томъёог цэгцлэх, зөв тодорхойлон бүртгэх, олон нийтэд сурталчлан, тайлбарлан таниулахад чухал ач холбогдолтой. Уг каталогид орж буй бүтээлүүдийн ихэнх хэсэг нь анх удаа хэвлэгдэн, олон нийтэд хүрч байгаагаараа онцлог юм.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, бүртгэх ажлын хүрээнд нэмэлт хийгдсэн ажлууд:

6. Дорноговь аймагт дахь Бүлээний овооны гэрэлт хөшөөг Монголын Үндэсний музейд шилжүүлэх ажил.

Соёлын өвийн төв Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ, Монголын Үндэсний музейтэй хамтран 2010 онд улсын бүртгэлд орсон Бүлээний овооны гэрэлт хөшөөг аюулгүй газарт татан авч хадгалах ажлыг 2011 оны 5 дугаар сарын 02-04 өдрүүдэд зохион байгуулсан.

Энэхүү гэрэлт хөшөө нь анхны байрлалдаа 185 см өндөр, 56 см өргөн 46 см зузаантай бөгөөд урагш харсан гадаргуу дээрээ 5 мөр Киданы их бичигтэй юм. Өнөөдрийн байдлаар Монгол болон хөрш зэргэлдээ БНХАУ-ын умард хэсгээр хад чулуунаа сийлсэн кидан бичээс бүхий дурсгал нийт 40 орчим илэрч олдоод байгаа бөгөөд тэдгээрийн дунд Бүлээний овооны гэрэлт хөшөөний бичээс шиг Кидан бичгийн утга соёлын зүй тогтолыг илэрхийлэх бичиг ховор юм.

Хөшөөг том ширхэгтэй боржин чулууг байгалийн тогтоцоор нь засалгүй газарт суулгасан бөгөөд өнөөдрийн байдлаар хөшөөний гадаргуу нэлэнхүйдээ барзайж зарим хэсэгтээ хагарал үүссэн нь чулуулгийн мөхлөг хоорондын холбоос сулрах үйл явц хурдацтай явагдаж байгаа, хөшөө нь нүцгэн уулын оройд оршиж байгаа нь элс, шороотой салхины нөлөөнд автаж гадаргуу нь хуурч унах явдал ч ажиглалтын явцад харагдаж байв. Чулуунд үүссэн дээрх гэмтлүүд нь уг хөшөөг цаашид хээр хөдөө, ил задгай газар урт удаан хугацаанд хадгалагдан үлдэх боломжгүй болгож байв.

Нөгөөтэйгүүр Өвөр Монголын Үндэсний Их сургууль кидан бичээс бүхий хөшөө дурсгалыг худалдаж авч цуглуулж байгаа тухай мэдээлэл сонсогдох болсон нь Дорноговь-Замын-Үүдийн төв замын дагуу оршиж байгаа энэ гэрэлт хөшөөг хулгайд өртөж болзошгүй эрсдлийг бий болгож байсан юм.

7. Цүүцийн голын хадны зосон зургийг бүртгэж баримтжуулалт

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачид Булган аймгийн Сэлэнгэ сумын 1-р багийн Засаг дарга н.Баатараас 2010 оны намар ирүүлсэн мэдээллийг шалгах, илэрсэн дурсгалыг бүртгэж баримтжуулах зорилгоор 2011 оны 5 дугаар сарын 11-нээс 5 дугаар сарын 17-ны өдрүүдэд Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт ажиллалаа. Тус судалгааны багт Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, сэргээн засварлагч судлаач Д.Нямдорж, мэргэжилтэн М.Нямбат, жолооч В.Баярсайхан нар оролцсон болно.

Цүүцийн гол бол Булган Сэлэнгэ сумын төвөөс зүүн тийш 90-100 орчим км, хуучны Атарын сангийн аж ахуй өнөөгийн Атарын 4-р багийн төвөөс баруун хойш 15-20 орчим км-т, Бүтээлийн нуруунаас эх аван урсаж Сэлэнгэ мөрний хойд талаас цутгадаг усны унац ихтэй жижиг гол юм. Энэ хавийн нутаг нь уул ус, ургамал мод, ан амьтнаар баялаг, хүн оршин сууж амьдрахад үлэмж тохиромжтой сайхан нутаг ажээ. Бидний өгүүлэн буй хадны зосон зургууд энэ голын дунд урсгалын баруун биед орших бөгөөд хоорондоо 3 орчим км зайтай байрладаг.

Цүүцийн голын баруун талаас орж ирсэн богино амны хойд үзүүрт орших дэллэсэн хадтай уулын зүүн урагш харсан ханан хадны гадаргуу дээр энэхүү зосон зураг бий. Энэхүү зосон зургаас баруун хойш нарийн амыг өгсөж 3 орчим км, явахад нэгэн давчуу амны дунд өнчин цохио бий. Энэ цохионы баруун урагш харсан гадаргуу дээр 2 зосон зургийн дурсгал бий. Цүүцийн голын хадны зурагт дүрсэлсэн хүн малын

зураг, тамга тэмдгүүдийг 0.7-1.6 см өргөнтэй улаан зосоор зурсан байв. Зарим зургийн биеийн гадна хөвөөг тод зурж дотор талд нь бүдэг өнгө тавьсан харагдана. Ийм арга адууны зурагт тод харагдана. Цүүцийн голын хадны зосон зургийн дурсгал нь байршиж буй газар нутаг, зургийн бүрдэл, зохиомж, дүрслэлийнхээ хувьд “Сэлэнгийн” гэгдэх зосон зургийн ангилалд хамаарах нь эргэлзээгүй ажээ.

8. Япон улсын Дошиша их сургуулийн мэргэжилтэнгүүдтэй хамтран Хэнтий аймгийн Рашаан хадны орчимд хийсэн бүртгэн баримтжуулалтын ажил

Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг орчин үеийн техник, технологи ашиглан бүртгэн баримтжуулах чиглэлээр 2009 онд хоёр байгууллагын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу энэ онд Соёлын өвийн төв, Япон Улсын Дошиша Их Сургуулийн мэргэжилтэн судлаачид Хэнтийн аймгийн Батширээт сумын нутагт орших олон үеийн дурсгалт Рашаан хадны орчимд баримтжуулалтын ажил хийлээ. Тус судалгааны ажилд Монголын талаас тус төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, программист Б.Алтансүх, Японы талаас Дошиша Их Сургуулийн мэргэжилтэн Хироши Ямагучи, орчуулагч, судлаач Шимүзү Нацуки, мэргэжилтэн Таппей Моримото болон жолооч Б.Эрдэнэчимэг нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг 2011 оны 8 дугаар сарын 4-нөөс 11-ныг дуустал 7 хоногийн хугацаатай ажилласан.

Рашаан хадны орчмын дурсгалт газрыг 3 хэмжээст дижитал технологиор баримтжуулах ажил хийлээ. Рашаан хад бол Монголын зүүн нутаг дахь чулуу, хүрэл, төмрийн үеийн түүхийн олон дурсгалыг хадгалсан түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн өндөр ач холбогдол бүхий цогцолбор дурсгалтай газар юм. Эндэхийн олон арван дурсгалыг Д.Пэрлээ, Д.Наваан, Д.Цэвээндорж, З.Батсайхан, Б.Цогтбаатар, Ц.Баттулга болон Оросын эрдэмтэн Э.А.Новгородова, Японы эрдэмтэн Мацукава зэрэг гадаад, дотоодын олон судлаачид шинжсээр ирсэн төдийгүй өдгөө ч тус газарт судалгааны ажил үргэлжилсээр байна. 2008-2010 онд Монгол-Японы хамтарсан “Их Хэнтий” төслийн хүрээнд Рашаан хадны чулуулгийн бүтцийн өөрчлөлт, эвдрэл гэмтлийн судалгааг хийж гарсан үр дүнд тулгуурлан авран хамгаалах чиглэлийн ажлыг хэрэгжүүлж байгаа бол, 2011 онд Монгол-Солонгосын хамтарсан судалгааны баг тус газарт чулуун зэвсгийн соёлт давхаргыг малтан шинжилж байна.

Судалгааны ажлын хүрээнд Япон мэргэжилтэнгүүдийн заавраар Total station төхөөрөмж дээр дадлагажин ажиллаж, газрын гадарга дээрх шаардлагатай нарийвчилсан хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

Рашаан хадны орчим орших хэд хэдэн дурсгал дээр Photogrammetry аргаар гурван хэмжээст модел боловсруулахад шаардлагатай хэрэглэгдэхүүн болох өндөр чанартай фото зураг авсан. Хэмжилт хийгдсэн таван цэг дээрээс орчныг бүхэлд нь 360⁰ харуулах боломжтой панорама-д хэрэглэгдэх зургийг тусгай зориулалтын төхөөрөмжийг ашиглан хийв.

9. Соёлын өвийн төвийн зориулалтын барилга

2011 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн БСШУЯамны төрийн нарийн бичгийн даргын 101 тоот тушаалын дагуу Соёлын өвийн төвийн барилгын зураг, төсөв боловсруулах, техник эдийн засгийн үндэслэл хийх гүйцэтгэгчийг солнгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж ажилласан бөгөөд ажлын хэсэг барилгын зураг төсөл

боловсруулах “Өрх” ХХК-ийг сонгон шалгаруулж, БСШУЯамны Барилга захиалагчийн алба, Санхүү хөрөнгө оруулалтын газар гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлэв. Тус төв барилгын техникийн өгөгдөл болон шаардлагатай мэдээллээр ханган оролцов.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ -2

БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 СББӨ-ийг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг батлуулах

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд ардын уламжлалт урлагийг төрийн ивээлд байлгаж, тэдгээрийг судлах, сургаж эзэмшүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, утга соёлын өв тээгчдийг тодруулан алдаршуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх талаар заасан байдаг.

Орчин цагийн Монголын нийгэмд гарч буй хамгийн том өөрчлөлт бол сууринших үйл явц эрчимжиж, нүүдлийн иргэншил эргэлт буцалтгүй задарч байгаа явдал юм. Эдүгээ Монголын хүн амын 3/2 хувь нь төв суурин газар, талаас илүү хувь нь нийслэл хотдоо оршин сууж буй статистик гарчээ. Монголын хотжилт нь ард иргэдийн жирийн нэг шилжих хөдөлгөөн биш, амьдралын нэг хэв маягаас огт өөр хэв маяг (нүүдэллэн аж төрөх ёсноос суурин аж төрөх ёсонд)-т шилжих шилжилт юм. Хотжисноор хүмүүсийн зөвхөн амьдралын орон зай өөрчлөгдөөд зогсохгүй, ахуй амьдрал, хэв заншил, уламжлалт соёлын олон үнэт зүйлс үндсээрээ өөрчлөгдөхөд хүрч байгаа билээ.

Ийм тохиолдолд нүүдлийн амьдралаас гарч, түүний салшгүй хэсэг болсон биет бус соёлын олон төрөл зүйлс түүний дотор мал аж ахуйн уламжлалт технологи, мал аж ахуйтай холбоотой, хур мэдлэг, туршлага ашиглагдахаа болж, нүүдлийн ёс заншил, гоо сайхны үнэлэмж, уртын дуу, үлгэр туульс, ардын бүжиг, бии биелэг, наадам, тоглоом нь хотын амьдрал, машин техникийн хэмнэлтэй төдийлөн таарахгүй учир орчин үеийн шоу цэнгээн, арилжааны соёлын хэрэглээгээр арга буюу солигдоход хүрч байна. Ийм эгзэгтэй хариуцлагатай үед Монгол Улсын СББӨ, түүнийг өвлөн уламжлагчыг судлан тогтоож эрдэм авъяасыг нь хойч үед өвлүүлэх, хадгалж хамгаалах, СББӨ-ийн талаар урт хугааны цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Соёлын биет бус өвийг хадгалж, хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулах бэлтгэл ажлын судалгаа шинжилгээний ажлын хүрээнд аймаг, нийслэлийн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн судалгаа, Яаралтай хамгаалах өв, Монгол Улсын төлөөллийн бүртгэлд олуулах өвийн санал, соёлын биет бус өвийн анхан шатны бүртгэл, тооллогыг 2010 оны нэгдүгээр улиралд хийж, дүнгээ аймаг, нийслэлийн салбар зөвлөлд ирүүлсэн бөгөөд аймаг, нийслэлээс нэгтгэн ирүүлсэн бүртгэл, жагсаалтыг нэгтгэн боловсруулж, 2010 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дүгнэв. Энэхүү судалгаа нь СББӨ-ийг хадгалж, хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулахад ихээхэн ач холбогдолтой бөгөөд судалгаагаар илрүүлсэн аймаг, нийслэлийн Яаралтай хамгаалах өв, Монгол Улсын төлөөллийн бүртгэлд оруулах өвийн санал зэргийг харгалзан хөтөлбөрийг боловсруулж байна.

Зорилго: Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан түүний тогтолцоог бүрдүүлэх, авран хамгаалах, судлах сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой. Зорилт:

1. Монгол Улсын хэмжээнд соёлын биет бус өвийн УНБМС-ийн тогтолцоо бүрдүүлэх
2. Монгол Улсын хэмжээнд соёлын биет бус өвийн бүхий л төрөл зүйлээр хэрэглэгдхүүн цуглуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх
3. Соёлын биет бус өвийг авран хамгаалах, судалгаа шинжилгээ хийх /судалгааны эргэлтэнд оруулах/
4. Монгол Улсын Үндэсний төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн бүртгэлийг нэмэгдүүлэх
5. ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад нэр дэвшүүлэх
6. Дэлхийн өвд бүртгэгдсэн “Увс нуурын ай сав газар” байгаль соёлын өв, “Орхоны хөндийн түүх соёлын дурсгалт газар” болон урьдчилсан жагсаалтад орсон газар нутагт СББӨ-ийн чиглэлээр бүс нутгийн хэмжээнд бүртгэн баримтжуулалт хийх
7. СББӨ-ийг түгээн дэлгэрүүлэх тэнхмийн болон шавь сургалт явуулах
8. СББӨ-ийг сурталчлах, хэвлэмэл болон дижитал, электрон танилцуулга, цомог, ном, CD, DVD, баримтат кино хийх
9. СББӨ-ийн талаар сургалт семинар, уулзалт ярилцлага, симпозиум, уралдаан наадмыг зохион байгуулах
10. Соёлын өвийн төв, СББӨ-ийг хамгаалах чиглэлээр ажилладаг судалгаа шинжилгээний хүрээлэн, музей холбогдох байгууллагыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
11. СББӨ-ийн чиглэлээр боловсон хүчин, мэргэжилтэн бэлтгэх
12. СББӨ-ийг сурталчлах цахим хэлбэрийн болон бодит хэрэглэгдхүүн дээр тулгуурласан “Соёлын биет бус өв”-ийн төрөлжсөн музей байгуулах
13. Өвлөн уламжлагчыг таньж тогтоох, жагсаалт гаргах, улсаас санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх
14. “ICHMON” программ хангамжийг бий болгох, СББӨ-ийн талаар үндэсний хэмжээний статистик мэдээ цуглуулах, боловсруулах, мэдээлэх
15. ЕБС-ийн сургалтын програмд соёлын биет бус өвийн чиглэлээр нэмэлт оруулах

2.2 “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт”-д “Монголын уламжлалт ган сийлбэрийн урлал”-ыг “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д “Монголын эртний уламжлалт эвэр нумын урлал”, “Монголын уламжлалт Шагай харвах зан үйл”-ийг нэр дэвшүүлэх номинацийн баримт бичиг хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх

БСШУ-ны сайдын 2011 оны 4 дүгээр сарын 26-ны 151 тоот тушаалын дагуу 2011 онд “Ган сийлбэрийн уламжлалт урлал”-ыг доктор Л.Батчулуун ахлагчтай баг Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад, “Нум сум хийх уламжлалт урлал”-ыг Ж.Сүхбаатар ахлагчтай баг, “Шагаа харвах зан үйл”-ийг Д.Басхүү ахлагчтай баг “Хүн төрөлхтний СББӨ-ийн төлөөллийн жагсаалт”-д тус тус нэр дэвшүүлж холбогдох баримт бичиг, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж хүргүүлэв.

Түүнчлэн өмнөх онуудад нэр дэвшүүлсэн “Уул овоо тахих монгол зан үйл”, “Монгол Цам”, “Төл авахуулах уламжлалт зан үйл”, “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа”, “Монгол жангар”, “Монгол уран бичлэг”, “Монголын цагаан сарын уламжлалт зан үйл”, “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”, “Монгол хувцасны уламжлалт

урлал” зэрэг өвүүдийн эх хэрэглэгдэхүүнийг олон улсын экспертүүдийн зөвлөмжийн дагуу засч, боловсронгуй болгох ажлыг холбогдох багуудтай хамтран гүйцэтгэв.

2011 оны 11 дүгээр сард Индонезийн Бали хотод болсон ЮНЕСКО-гийн конвенцийн засгийн газар хоорондын хорооны ээлжит чуулга уулзалтаар Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа”-г Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалтад бүртгэн тунхагласан нь манай хамт олон, холбогдох мэргэжилтнүүдийн багийн ажлын үр дүнг илтгэсэн баяртай үйл явдал боллоо.

2.3 Ардын урлагийн их наадмын 2, 3 дугаар шатанд шалгарсан төв, орон нутгийн ардын авъяастнуудын урын сан, ур чадварыг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж архивлах

БСШУ-ын сайдын 2010 оны 299 дүгээр тушаалын дагуу Ардын урлагийн их наадмыг зохион байгуулах тухай, “Соёлын өвийг хамгаалах тухай” хуульд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын авьяас билгийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, билиг авъяастныг тодруулах зорилгоор 5 жил тутам улсын хэмжээнд Ардын урлагийн их наадмыг зохион байгуулж байх”-аар хуульчилсны дагуу энэ онд зохион байгуулагдсан.

Энэхүү наадмын II ба III шатны шалгаруулалтыг баримтжуулах ажлын явцад Увс, Завхан, Өвөрхангай, Дундговь, Орхон, Дорнод, Төв аймаг, Улаанбаатар хотын Багануур, Хан-Уул дүүрэгт зохиогдсон бүсийн шалгаруулалтад оролцогч ардын авъяастан, өвлөн уламжлагчдийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлж ажиллалаа.

Наадамд оролцогч ардын авъяастнуудын урын санг нийт 4200 минутын дүрс бичлэг, 2475 ширхэг гэрэл зургаар баримтжуулав.

2.4 Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд буй соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчдын урын сан, ур чадварыг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах

2011 оны эцсийн байдлаар СББӨ-ийн төрөл зүйл, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлд тооллогод Улаанбаатар хотын 9 дүүргийн 128 хорооны 15 өвийн төрөл зүйл, 1337 өвлөн уламжлагч бүртгэгдээд байна. 2011 онд зохион байгуулагдсан Ардын урлагийн их наадамд дүүрэг бүрээс шалгаран оролцсон 194 ардын авъяастныг 720 минутын дуу, дүрс бичлэгээр баримтжуулан, тухайн өвлөгчтэй холбогдох мэдээлэл, гэрэл зургийг бүрдүүлэн, цаасан суурьтай болон цахим хэлбэрийн архив үүсгэн хадгалж байна.

2.5 ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай болон хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад орсон өвийг хамгаалах:

Үр дүнгийн гэрээнд тусгагдсан *“Бий биелгээ” тэдгээрийн уламжлалт татлагаар DVD хийж, хэвлүүлэн олон нийтэд сурталчлах, “Монгол тууль”-ийн өвлөн уламжлагдсан өнөөгийн бодит төвшинг тогтоох, тууль хайлах язгуур зан үйлийг*

нийтэд сурталчлах зэрэг төлөвлөгдсөн ажлууд нь санхүүжилтгүйн улмаас тодорхойгүй хугацаагаар хойшилогдсон.

- “Цуур”, “Сыбызга” хөгжмийн уламжлалт урын сангийн аудио CD-г тайлбар хавсралтын хамт хэвлэн сурталчлах

Монгол цуур хөгжмийн урлаг 2009 онд “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-ийн жагсаалт”-д бүртгэгдсэн. Уламжлалт цуур хөгжмийг сурталчлах, хойч үед өвлүүлэх болон цуур хөгжмийг судлаачид, эхлэн суралцагчид, сонирхогчдод зориулсан гарын авлага болгож 40 минутын баримтат кино, хавсралт товхимолыг бэлтгэж хэвлэлтэнд өгөөд байна.

- “Уртын дуу”-ны ястан угсаатан, бүс нутгийн онцлогийг тусгасан шавь сургалтыг зохион байгуулах

Монгол ардын уртын дууг судлах, сурталчлах ажлын хүрээнд Боржигин уртын дуу, Боржигин найрын зан үйлийн онцлогийг хойч үед өвлүүлэх, олон нийтэд сурталчлах зорилгоор “Боржигин найр” баримтат кино (DVD) бүтээв.

2.6 Дэлхийн өвд бүртгэгдсэн болон Үндэсний жагсаалт дахь СББӨ-ийг дуу дүрс бичлэг, цахим болон хэвлэмэл байдлаар бүх нийтэд сурталчлах

Дэлхийн өвд бүртгэгдсэн болон Монгол Улсын үндэсний төлөөллийн жагсаалт дахь СББӨ-ийг дуу дүрс бичлэг, цахим болон хэвлэмэл байдлаар бүх нийтэд сурталчлах ажлын хүрээнд “Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй төрөл зүйлс” цомог хэвлүүлэн гаргалаа. Энэхүү цомогт:

- Монгол Улсаас ЮНЕСКО-гийн СББӨ-ийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн “Монголын морин хуурын уламжлалт урлаг” (2003)(2008), “Монгол ардын уртын дуу” (2005)(2008), “Монгол хөөмэйн уламжлалт урлаг” (2010), “Монгол наадам” (2010), “Бүргэдийн ан буюу шувуучлахуй” (2010),

- Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол бүжгийн уламжлалт урлаг- бий бийлгээ” (2009), “Монгол тууль” (2009), “Монгол цуур хөгжмийн урлаг” (2009), “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” (2011) зэрэг өвүүдийн танилцуулга,

- “Дэлхийн Баримтат өвийн жагсаалт”-д бүртгэгдсэн Лу.”Алтан Товч”, “Монгол Шунхан Данжуур” 2 өвийн танилцуулга,

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 03 дугаар сарын 5-ний өдрийн 293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Соёлын биет бус өвийн Төлөөллийн Үндэсний жагсаалт”, “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн Үндэсний жагсаалтад бүртгэгдсэн 88 төрөл зүйлсийн товч танилцуулга, БСШУ-ны сайдын тушаалаар “СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын билиг авъяастнуудын улсын жагсаалт”-д бүртгэгдсэн 100 авъяастны товч танилцуулга, гэрэл зургууд тус тус орсон.

2.7 Соёлын биет бус өвийн бүртгэл-мэдээллийн сангийн үндэсний тогтолцоог боловсронгуй болгох, бүртгэл-мэдээллийн програм хангамжийг боловсруулж эхлэх, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх

Монгол Улсын хэмжээнд байгаа бүх СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн талаарх эрдэм шинжилгээний үнэн зөв бодит мэдээллийг цуглуулан авахад зориулж, тусгайлан

боловсруулсан өгөгдөл бүхий бүртгэн баримтжуулах програм хангамж зохиох, бүртгэл хийх байгууллагыг зөвхөн энэ ажилд зориулан өндөр хүчин чадалтай компьютер, гэрэл зургийн техник тоног төхөөрөмжөөр хангах, интернет шугам сүлжээ үүсгэх, СББӨ-ийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сүлжээ, электрон архив сан үүсгэн бий болгох, мэдээлэл нэгтгэх, боловсруулах ажлыг зохион байгуулах, үндэсний СББӨ-ийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах нь зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай зорилтуудын нэг болж байна.

Үүнээс улбаалан “**Intangible cultural heritage of Mongolia (ICHMON)**” нэр бүхий Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх бүртгэлийн програм нь БСШУ-ны сайдын 2010 онд 541-р тушаалаар шинэчлэн баталсан “Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах бүртгэл”-ийн ерөнхий хэв загварыг баримтлан ажиллахаар хийгдэж байгаа болно.

Энэхүү програм нь аймаг, нийслэл, сум, дүүргийн нэгж байгууллагад буй СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн талаарх дэлгэрэнгүй, үнэн зөв бодит мэдээллийг тусгайлан бэлдсэн асуулт, өгөгдлийн дагуу бичиж архивлан хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, хүссэн мэдээллээ түргэн хугацаанд олж авахад зориулагдсан. Програм нь гэрэл зургийн өгөгдөл оруулах, интернет шугаманд ажиллах боломжоор хангагдсан байх болно.

Соёлын өвийн төв нь СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх 2 төрлийн програм хангамж зохионо. Үүнд:

- **СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл**

Уг бүртгэлээс Өвлөн уламжлагчийн мэдээлэл (нэр, нас, хүйс, регистрийн дугаар, байршил, алдар цол, гавьяа шагнал, хаяг, холбоо барих мэдээлэл г.м), СББӨ-ийг өвлөн уламжлагчийн тоог насны ангиллаар, бүс нутгаар, аймаг, сум, дүүргээр болон мөн ангилал, төрөл зүйл тус бүрээр нарийвчлан гаргах зорилгыг чиглэл болгон зохионо.

Мөн өвлөн уламжлагчийн тухайн өвөө үйлдэж буй дуу, дүрс бичлэг, гэрэл зургаас хэсэгчлэн оруулахдаа тэдгээрийн архивт хадгалагдаж буй дугаарласан дугаарыг програмд хавсаргаж өгнө.

- **СББӨ-ийн тухай мэдээлэл**

СББӨ-ийг өвлөн уламжлагчийн бүртгэл, тухайн хүний өвлөсөн биет бус өвийн тухай мэдээлэл дээрээс үндэслэн зөвхөн СББӨ-ийн илэрхийллийн тухай ерөнхий, нэгдсэн мэдээлэл гаргана. Үүнд:

1. СББӨ-ийн илэрхийллийг тайлбарласан тодорхойлолт, зурагтай хамт байна.
2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа нийт СББӨ-ийн илэрхийллийн тоо, тэдгээрийн ангилал, төрөл зүйл бүрийн тоог гаргана.
3. СББӨ-ийн төрөл зүйл тус бүрийн Монгол Улсын хэмжээн дэх тархац газрын зураг дээр харагдах байдлаар гарна.

Өмнөх 2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 2.1 буюу “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах програм хангамжийн техникийн өгөгдөл бэлдэх тухай” ажлын хүрээнд эхний ээлжинд “СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдыг бүртгэх” програмын ажиллах зарчим, ерөнхий загвар, дизайныг хайлтын систем бүхий хялбарчилсан байдлаар ашиглах зориулалтаар боловсруулан гаргасан болно.

Уг бүртгэлийн програмыг ашиглан СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдийн талаар төрөл бүрийн нарийвчилсан статистик мэдээлэл гарган авч цаашид УБМС-н боловсруулан сайжруулах, СББӨ-ийг хадгалж хамгаалах, хойчид өвлүүлэх, түүнийг

өвлөн уламжлагчдыг дэмжих талаар судалгаа гаргах, хөтөлбөр боловсруулахад дөхөм болоход нэн шаардлагатай юм. Бүртгэлийн програмыг СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах ажил хийх эрдэм шинжилгээний ажилтнууд өргөн хэрэглэхээр техникийн өгөгдлийг боловсруулсан.

Монгол Улсын СББӨ-ийн язгуур хэв шинж, түүнийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх, баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайдын 2009 оны 414 дугаар тушаалаар “Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам” батлагдан, уг ажил улсын хэмжээнд 2 дахь жилдээ хийгдэж дүнгээ гаргаад байна.

2010 онд СББӨ, түүнийг өвлөгчийн бүртгэл, тооллогыг улсын хэмжээнд анх удаа явуулж, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны нэгжийн 80.1%-ийг хамруулав. СББӨ, түүний өвлөгчийн анхан шатны бүртгэлд 21 аймгийн 283 сум, нийслэлийн 9 дүүргийн 106 хорооны 3540 өвлөгч хамрагдсан юм. /Хүснэгт 6,7/2011 оны шинэчилсэн бүртгэлээр энэ статистик 314 сум, нийслэлийн 9 дүүргийн 128 хорооны 5504 өвлөгч болж өргөжсөн байна. /Хүснэгт8/ Энэ нь улсын хэмжээнд буй засаг захиргааны нэгжийн 91.8%-ийг хамарсан үзүүлэлт юм. Бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх явцад 150 гаруй СББӨ-ийн төрөл зүйл бүртгэгдээд байна.

Орон нутгийн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн дүн

Хүснэгт 6

№	Аймгийн нэр	Нийт сумд	Бүртгэлд огт хамрагдаагүй сумдын нэрс	2010 оны	2011 оны	Нийт өвлөгчид
				бүртгэлд хамрагдсан өвлөгчдийн тоо		
1	Архангай	19	Жаргалант, Их тамир, Хайрхандулаан, Хангай, Цэцэрлэг	99	5	104
2	Баян-Өлгий	13		30	152	182
3	Баянхонгор	20	Баацагаан	196	61	257
4	Булган	16		89	0	89
5	Голвь-Алтай	18		167	116	283
6	Говьсүмбэр	3		32	34	66
7	Дархан-Уул	4	Хонгор	12	6	18
8	Дорноговь	14	Замын-Үүд, Иххэт, Хатанбулаг	93	2	95
9	Дорнод	14		125	6	131
10	Дундговь	15		163	72	235
11	Завхан	24		373	97	470
12	Орхон	2	Жаргалант	18	2	20
13	Өвөрхангай	19		76	83	159
14	Өмнөговь	15		101	63	164
15	Сүхбаатар	13	Наран, Уулбаян	53	60	113
16	Сэлэнгэ	17		173	241	414
17	Төв	27	Баянцогт	221	64	285
18	Увс	19		207	5	212
19	Ховд	17		213	2	215
20	Хөвсгөл	23		234	207	441
21	Хэнтий	18		214	0	214
	Нийт	330	14	2889	1278	4167

Нийслэлийн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн дүн

Хүснэгт 7

№	Дүүргийн нэрс	Хороодын тоо	Бүртгэлд огт хамрагдаагүй хороо	2010 оны	2011 оны	Нийт өвлөгчид
				бүртгэлд хамрагдсан өвлөгчдийн тоо		
1	Багануур	5	2	17	138	155
2	Багахангай	2		39	16	55
3	Баянгол	23	23	118	151	269
4	Баянзүрх	28	21,22, 25,26,28	132	64	196
5	Налайх	7	6	29	57	86
6	Чингэлтэй	19	14,15,17	29	63	92
7	Сонгинохайрхан	32	2, 9, 19, 26, 27, 28, 29, 30, 31, 32	78	60	138
8	Сүхбаатар	18+2	6,7	72	37	109
9	Хан-Уул	15		137	100	237
	Нийт	151	23	651	686	1337

2010, 2011 оны өвлөн уламжлагчдын нэгдсэн дүн Хүснэгт 8

№	Засаг захиргааны нэгж		2010 оны	2011 оны	Нийт өвлөгчийн тоо
			бүртгэлд хамрагдсан өвлөгчдийн тоо		
1	21 Аймаг	316 сум	2889	1278	4167
2	9 дүүрэг	128 хороо	651	686	1337
			3540	1964	5504

Бусад ажлын талаар:

“Соёлын биет бус өвийг хамгаалах” тухай ЮНЕСКО-ийн конвенцийн хэрэгжилтийн үндэсний тайлан илтгэл боловсруулах ажил:

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн конвенцийн хэрэгжилт, Монгол Улсаас Хүн төрөлхтний СББӨ-ийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүдийн өнөөгийн төлөв байдал, СББӨ, түүний өвлөн уламжлагчийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаарх үндэсний тайлан, илтгэлийг боловсруулж, орчуулах ажлыг хариуцан ажиллалаа.

СББӨ-ийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн конвенц батлагдсанаас хойшхи хугацаанд Монгол Улс “Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол ардын уртын дуу”, “Монгол хөөмэйн уламжлалт урлаг”, “Монгол баяр наадам”, “Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл” зэрэг 5 өвийг СББӨ-ийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад, “Монгол бүжгийн уламжлалт урлаг-Бий биелгээ”, “Монгол тууль”, “Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” зэрэг 4 өвийг Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад тус тус бүртгүүлээд байна.

“Иргэний боловсрол” сурах бичгийн хэрэглэгдэхүүн боловсруулах ажил:

Монгол Улсын төрөөс баримтлах Соёлын бодлого хэмээх баримт бичгийн үзэл санаа, “Иргэнийг багаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох эрэмбэ дараатай ажлыг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох” тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу ЕБС-ийн I, II, III ангид үзэх “Иргэний боловсрол” хичээлийг шинээр буй болгож холбогдох сурах бичгийн агуулгад монголчуудын СББӨ-ийн гол төлөөлөл болсон монгол гэр, морин хуур, уртын дуу, хөөмэй, бий бийлгээ, монгол хувцас, монгол наадам, цагаан сарын ёслол, мэндлэх хүндлэх уламжлал, мал маллах ухаан, нүүдэлчдийн байгаль хамгаалах уламжлал зэрэг сэдвийг сурагчдын насны онцлогт (6-8 нас) тохируулан тусгахад арга зүйн зөвлөгөө өгч, уг хичээлийн сургалтад ашиглах “Би Монгол хүн” видео хэрэглэгдэхүүний эхийг бэлтгэв.

СББӨ-ийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйн дадлага сургалт:

2011 оны 1 дүгээр сард Сэлэнгэ аймгийн боловсрол, соёлын газар (БСГ)-тай хамтран “Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх, баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” сэдвээр сургалт явуулж, уг сургалтад Сэлэнгэ аймгийн нийт сумдын СББӨ-ийг хариуцсан мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан.

2011 оны 7 дугаар сард Биет соёлын өвийг хамгаалах хэлтэс, Сэргээн засварлах хэлтсийн мэргэжилтэнгүүдтэй хамтран баруун бүсийн аймгуудын музейн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлт, үйл ажиллагаатай танилцаж СББӨ-ийн БМС-г бүрдүүлэх арга зүйн зөвлөгөө өгөв. /”Бүтээгдэхүүний анги-1” -д дэлгэрэнгүй орсон болно/

СББӨ-ийн төрөл зүйлийн Батламж хүлээн авах ёслолын ажиллагаа:

Монгол Улсаас Хүн төрөлхтний СББӨ-ийн төлөөлийн ЮНЕСКО-ийн жагсаалтад “Шувуучлахуй буюу Бүргэдийн ан”, “Монгол хөөмэйн уламжлалт урлаг” өвүүдийг бүртгэн тунхагласан батламж хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгуулан түүнд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, тухайн өвүүдийг олон нийтэд сурталчилсан тус бүр 30 минутын баримтат кино (DVD) бүтээв.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-3

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Улс, аймгийн 12 музейн 140 ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах:

2011 онд Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс нь улс, аймгийн 11 музейн 139 үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлахаар төлөвлөж ажилласан.

№	Байгууллага	Нийт сэргээн засварлах үзмэрийн тоо	Хүлээж авсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагдаж байгаа үзмэрийн тоо	Сэргээн засварлагдсан үзмэрийн тоо	Засварт ороогүй үзмэр
1	Богд хааны ордон музей	20	20	1	17	2
2	Уран зургийн галерей	20	10	1	7	2
3	Монголын үндэсний музей	18	18		17	1
4	Археологийн хүрээлэн	2	2		2	
5	Сэлэнгэ аймгийн музей	8	4		4	4 үзмэр ирээгүй
6	Сүхбаатар аймгийн музей	22	22	3	14	5

7	Дундговь аймгийн музей	10	10 2011.12.20нд хүлээж авсан			10 2012 оны ажилд оруулсан
8	Булган аймгийн музей	8	8	1	7	
9	Хөвсгөл аймгийн музей	6	6	2	4	
10	Завхан аймгийн музей	15	15	1	14	
11	Дорнод аймгийн музей	10	10		10	
	Нийт	139	125	9	96	10

2011 онд нэмэлт захиалгаар сэргээн засварласан музейн үзмэрүүд

№	Байгууллага	Металл	Мод	Цаас	Тайлбар
1.	Булган аймгийн музей	1			Хонх очир
2.	Хөвсгөл аймгийн музей	1			Богд зонхов
3.	Завхан аймгийн музей	1			Богд ламын дүр
4.	Сэлэнгэ аймгийн музей		3		Хувьсгалын цэрэг сийлбэр, Сүхбаатар жанжны сандал 2 ширхэг
5.	Богд хааны ордон музей	1			Богд хааны тамганы хуулбар
6.	Монголын үндэсний музей	4			Богд хааны тамганы хуулбар, хүрэл толь, хүрэл товруу, жадны үзүүр
7.	Үндэсний номын сан			25	Үзмэрт зориулсанхайрцаг
8.	Эрдэн зуу музей		1		Зандан зуу сийлбэр
	Нийт	8	4	25	12 үзмэр нэмж засварласан

3.2 Монголын Уран зургийн галерейн 50 ширхэг уран зургийг утаа тортогний бохирдлоос цэвэрлэх:

2008 оны 7 дугаар сарын 1-ны үйл явдал, 2009 оны 5 дугаар сарын 18-нд тус музейн сан хөмрөгт гарсан галнаас утаа тортогт бохирдож, усанд норж гэмтсэн 900 гаруй зургаас энэ жил төлөвлөсний дагуу 50 ширхэг зургийг цэвэрлэх ажил хийгдэж дууссан.

3.3 Аялал жуулчлалын бүсэд хамрагдсан 4 ширхэг газар танилцуулга самбар хийлгүүлэх:

2011 онд Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дуутын хадны цогтын бичээс, Их хөшөөтын дурсгал, Булган аймгийн Дашинчилэн сумын Цогтын цагаан байшин, мөн аймгийн Могод сумын Хөл асгатын дурсгал зэрэг газруудад байрлуулах 4 ширхэг танилцуулга самбарыг захиалгаар хийлгүүлж, байрлуулах ажлыг 2-4 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн.

3.4 2011 он “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7-5, 3-4. Рашаан хад, Сэрвэн хаалганы дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах:

2011 онд Япон улсад байгалийн бэрхшээл тохиолдсоны улмаас Хэнтий аймгийн Рашаан хад, Сэрвэн хаалганы дурсгал дээр хамтарч ажиллахаар судлаачид ирээгүй тул хүндэтгэх шалтгааны улмаас энэхүү нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэгжээгүй болно.

3.5 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.3-ийн дагуу:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дуутын хадны Цогтын бичээс, Булган аймгийн Могод сумын Хөл асгатын дурсгалуудыг цэвэрлэх, хэв авч хуулбарыг хийх ажлын хүрээнд 2011 оны 6-р сарын 22-ноос 29-ний хооронд сэргээн засварлагч С.Чинзориг, С.Даваадарь, А.Мөнгөнцөөж, Э.Батжаргал нар хийж гүйцэтгэв.

**2011 онд Үр дүнгийн гэрээгээр сэргээн засварласан болон нэмэлт захиалгаар
сэргээн засварласан үзмэрүүд**

№	Байгууллага	Улс аймгийн музейн Сэргээн засварласан үзмэрийн тоо	50 ширхэг уран зургийг угаа тортогний бохирдлоос цэвэрлэх:	Нэмэлт захиалгын ажил Төв аймгийн Заамар сум Шороон бумбагараас гарсан олдворуудыг сэргээн засварлах ажил	Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хөрмийн шороон бумбагарын олдворыг хамгаалах ажил	Чойжин ламын сүм музейн зуу сүмийн бурхадын агуйн хадны эвдрэл, бурхадын чимэглэлүүд, гарын барьц, хөл гарын гэмтлийг сэргээн засварлах ажил	Үндэсний музейн үзмэр Түрэгийн үед холбогдох дурсгалуудаас хуулбар хийх ажил	Бага эрээний хүн чулуун дурсгалаас хэв авч хуулбарыг хийж музейд байрлуулах, эх дурсгалыг музейгээс татаж унаган эх газарт нь байрлуулах ажил	Бүлээний овооны гэрэлт хөшөөг татаж Монголын Үндэсний музейд байрлуулах, эх дурсгалаас хэв авах ажил	Гол мод-2 хүннүгийн булшны олдворуудад анхан шатны цаварлалгаа бэхжилдэлт хийх ажил	Музейн үзмэр	Бүгд
1.	Богд хааны ордон музей	17									1	1
2.	Уран зургийн галерей	7	50									57
3.	Монголын үндэсний музей	17							1		4	22
4.	Археологийн хүрээлэн	2										2
5.	Сэлэнгэ аймгийн музей	4									3	7
6.	Сүхбаатар аймгийн музей	14										14
7.	Булган аймгийн музей	7									1	8
8.	Хөвсгөл аймгийн музей	4									1	5
9.	Завхан аймгийн музей	14									1	15
10.	Хар хорум музей				100 гаруй			1				100 гаруй
11.	Чойжин ламын сүм музей					15						15
12.	Дорнод аймгийн музей	10										10
13.	Дүрслэх урлагийн музей			60 орчим								60 орчим
14.	Хөшөө цайдамын музей						62					62
15.	Эрдэнэ- зуу музей										1	1
16.	Үндэсний номын сан										25	25
17.	Улаанбаатар их сургууль									100 гаруй		100
	Нийт	96	50	60	100	15	62	1	1	100		485

Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх талаар:

- Соёлын өвийг судлах хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх ажлын хүрээнд 2011 оны 3-р сарын 19-ноос 4-р сарын 1-ний хооронд Герман улсын Гёте-Институт, ЮНЕСКО-гоос хамтран зохион байгуулсан цаасан дээрх баримтат өвийг сэргээн засварлах сургалтанд сэргээн засварлагч О.Оюунчимэг, А.Мөнгөнцоож нар оролцож сургалтанд хамрагдсан.
- 2011 оны 10-р сарын 17-22нд Улаанбаатар хотноо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Япон улс дахь ЮНЕСКО-гийн Ази номхон далайн орнуудын соёлын төвийн соёлын өвийг хамгаалах хамтын ажиллагааны газартай хамтран соёлын өвийг хамгаалах сургалт дадлагын ажилд сэргээн засварлагч С.Чинзориг, С.Даваадарь, Т.Амартүвшин, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар сургалтанд хамрагдав.
- Япон улсын JICA байгууллагын шугамаар БСӨХХэлтсийн дарга Д.Нарантуяа 2011 оны 6 дугаар сараас 9 дүгээр сарыг хүртэл мэргэжил дээшлүүлэх “Музей судлалын эрчимжүүлсэн сургалт”-нд хамрагдсан.
- Япон улсын Киото хотноо 2011 оны 12-р сарын 4-нөөс 15-ний хооронд Япон сангаас зохион байгуулсан “Цаасан суурьт өвийг сэргээн засварлах” сургалтанд сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн оролцсон.
- АНУ-ын Вильямастоуны хотын уран зураг сэргээн засварлах төвд уран зургийн сэргээн засварлалтын чиглэлээр сэргээн засварлагч Д.Нямдорж 2011 оны 11-р сараас 6 сарын хугацаатай сургалтанд хамрагдаж мэргэшил, ур чадвараа дээшлүүлж байна.

Сэргээн засварлалт хийгдэж байгаа үзмэрүүдээс:

Өвөрхангай аймгийн Хархорин сум Эрдэнэзуу музейн Зандан зуу сүмийг багасгаж сум модоор хийсэн сүмийг сэргээн засварлах ажил, Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хулхын амны 7-9 дүгээр зууны үед холбогдох булшнаас гарсан шавар арсланг сэргээн засварлах зэрэг ажлууд хийгдэж байна.

Нэмэлт захиалгаар гүйцэтгэсэн томоохон ажлууд:

1. Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, ОХУ-ын Буриадын Монгол-Түвд-Буддын судлалын хүрээлэнгийн хамтарсан судалгааны анги 2009 оны 7 дугаар сард Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Шороон бумбагар хэмээх газраас Түрэгийн эзэнт гүрний үед холбогдох бунхныг судлах малтлагын үеэр тус бунхнаас олон тооны өвөрмөц сонин олдворууд гарсныг 2009 оны 7 дугаар сарын 13-16-ны хооронд малтлагын талбай дээр тус төвөөс сэргээн засварлагч ажиллаж, олдворуудад анхан шатны хамгаалалт, бэхжүүлэлтийг хийж авчирсан. Зарим шаардлагатай 50 гаруй олдворуудыг 2009 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах ажлыг хийж

гүйцэтгэсэн. 2010 оны 3 дугаар улиралд дээрх олдворуудыг бүрэн хэмжээгээр бэхжүүлж сэргээн засварлах ажил эхэлж, 2011 оны эхний улиралд сэргээн засварлах ажлыг дуусгаж Дүрслэх урлагийн музейнд шилжүүлэн өгсөн.

2. Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хэрмийн шороон бумбагар хэмээх газарт орших VI-VII зууны үед холбогдох түргийн үеийн бунханта оршуулагын байгууламжийг нээх археологийн судалгааг Монгол Улсын ШУА-ийн харьяа Түүхийн хүрээлэн, Казакстан улсын Астана хот Л.Н.Гумилевийн нэрэмжит Евразийн үндэсний их сургуулийн судлаачидтай хамтарсан судалгааны баг 2011 оны 7-8 дугаар сард малтлагын ажлыг хийсэн. Хоёр талын хөмөг болон бунханд олон тооны босоо хүний баримал морьт цэрэг, морь, тэмээ, арслан, үхэр, луу, галбингаа, модон хаалга, даавуун материал, алтан зоос, алт шармал хүрэл эдлэл зэрэг олон тооны олдвор гарсан. Бунханыг нээж олдворуудыг хамгаалалтанд авах, анхан шатны цэвэрлэгээ. бэхжүүлэлт хийх, зөөж тээвэрлэх ажилд сэргээн засварлагч Д.Нямдорж Н.Бат-Эрдэнэ нар 2011 оны 8 дугаар сард 14 хоног ажиллав. Бунхны ханын зургийг хамгаалах бэхжүүлэх ажилд сэргээн засварлагч С.Чинзориг, Н.Бат-Эрдэнэ нар 2011 оны 9 дүгээр сард 15 хоног ажилласан.
3. Чойжин ламын сүм музейн зуу сүмийн бурхадын агуй хадны эвдрэл, бурхадын чимэглэлүүд, гарын барьц, хөл, гарын гэмтэл зэргийг сэргээн засварлах ажлыг 2011 оны 6 дугаар сарын 8-наас 24-ны хооронд хийж гүйцэтгэсэн.
4. Архангай аймгийн Хашаат сумын нутаг дахь Хөшөө цайдамын музейн үзмэрт зориулж Үндэсний музейн үзмэр Түрэгийн үед холбогдох 24 төрөл зүйлийн дурсгалуудаас 62 ширхэг хуулбарыг хийж, тус музейд хүлээлгэн өгөв.
5. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хархорум музейд байсан Бага эрээний хүн чулуун дурсгалаас хэв авч хуулбарыг хийж музейд байрлуулах, эх дурсгалыг эгүүлэн татаж унаган газарт нь байрлуулах ажлыг хийсэн.
6. АНУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх соёлын өвийн хамгаалах тусгай зориулалтын сангийн санхүүжилтээр Монголын уран зургийн галерейн галд өртөж шатаж гэмтсэн уран зургийг сэргэн завсарлах зорилгоор тусгай сэргээн засварлалтын зориулалтын халдаг ширээ болон сэргээн засварлалтанд хэрэглэдэх зарим түүхий эд, бодисыг хүлээн авав.
7. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын ажлын албаны нарийн бичгийн даргын тушаалаар 2011 оны 3-5 дугаар сард түүх, солёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын байдалтай танилцах, цаашид дурсгалыг хэрхэн хамгаалах талаар санад дүгнэлт гаргах зорилготой ажлын хэсэгт захирал Г.Энхбат болон сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар ажиллав.

Соёлын өвийн төвөөс соёлын өвийг хамгаалахад зориулж цаашид авах арга хэмжээний санал:

2011 онд улсын төсвөөс тус төвийн төвийн зориулалтын барилгын зураг, төсвийг “Өрх” ХХК-аар хийлгүүлсэн бөгөөд барилга ашигалалтанд орох үед шаардлагатай сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах тоног төхөөрөмжөөр дэс дараалалтай хангах асуудлыг онцгой анхаарч, жил тутамд тоног төхөөрөмж худалдан авахад зориулж хөрөнгө оруулалтын хэлбэрээр 50-60 сая төгрөг төсөвлөх шаардлага гарч байна.

Сүүлийн жилүүдэд сэргээн засварлах ажил нь зөвхөн музейн үзмэр бус хээр хөдөө орших хөшөө чулуу бэхжүүлэх сэргээн засварлах, археологийн малталтаас гарч ирж буй олдворуудыг газар дээр нь болон лабораторт бэхжүүлэх, сэргээн засварлах, эртний булш бунханы ханын зураг болон нээлттэй музей музей болгохд шаардлагатай анхан шатны бэхжүүлэлтийн ажлууд ихээр хийгдэх болсон тул байнга ашиглагддаг зарим нэр төрлийн хэрэгцээт химийн бодисууд хүрэлцээгүй болсон, материалууд нь дотоодын зах зээлд байдаггүй, гадаад зах зээлээс худалдан авахад өнөөгийн төсөв нь бага тул сэргээн засварлах ажлын материал худалдан авах төсөв нэмэгдүүлэх, химийн бодис импортоор оруулж ирэх, хэрэглэж болох тусгай лиценз, зөвшөөрөл авах хэрэгцээ байна.

Музейн бүртгэн баримтжуулалт музей бүр дээр харилцан адилгүй хийгдэж байгаа нь үзүүлэлтээс харагдаж байгаа тул бүртгэлийн ажилд музейн удирдлагууд хүн цаг хугацааг түлхүү тавьж өгөх, ажилтныг тогтвор суурьшилтай ажилуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна. Мөн музейд мониторинг шалгалт хийхдээ соёлын өв музейн үзмэрийн бүртгэн баримтжуулалтын талаарх тоон үзүүлэлт, биелэлтийг шалгуур үзүүлэлтээ нэмж оруулах хэрэгцээ байна.

Хээр хөдөө оршиж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, орон нутгийн хүрээнд хийгдэж буй газрын хэвлий түүнтэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын үед авран хамгаалах чиглэлээр тусгайлсан ажил зохион байгуулах шаардлага гарч ирж байна.